

Илтгэлийн нэр:

Дорнод аймгийн Хэрлэн сумын Хан-Уул цогцолбор загвар сургуулийн багшлахуйн арга зүйг шинэчлэх, хөгжүүлэхэд чиглэсэн менежментийн талаар хэлэлцэх илтгэл

Судалгааны сэдэв:

“Хичээлийн судалгааны аргаар багшийн заах арга зүй, ур чадварыг дээшлүүлэх нь”

Сэдэв сонгосон шалтгаан:

Цогц чадамжид суурилсан бага, дунд болвсролын шинэ стандартыг хэрэгжүүлэх явцад багш бүхэн сургалтын шинэ арга зүйг эзэмших зайлшгүй шаардлага бодитойгоор урган гарч ирсэн. Энэүү шаардлагыг хангах зорилгоор Монгол Улсын БШУЯ нь Японы ЖАЙКА байгууллагатай хамтран 2006 оноос “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил”, 2010 оноос “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх нь” сэдэвт төслийн хэрэгжүүлсэн билээ. Бид энэхүү төслийн сургалтад хамрагдсанаар хичээлийн судалгааны талаар ерөнхий ойлголттой болж, сургуульд суурилсан хичээлийн судалгааг туршин хэрэгжүүлж байна. Тус бага сургууль нь хичээлийн жилийн эхэнд аль ангид ямар хичээлээр /заахад, сурагчдад ойлгуулахад хүндрэлтэй сэдэв/ хэзээ судалгаат хичээл явуулах вэ гэдгийг багш нартайгаа харилцан ярилцаж хуваарь гарган ажилладаг. Монгол хэл, математик, хүн орчин, иргэний боловсрол, хүн байгаль хичээлүүдээр судалгаат хичээлийг зохион байгуулсан ба хүн байгаль хичээлийг заахад багшаас онолын мэдлэг, ажиглалт, туршилт судалгаа хийх арга зүй, ур чадварыг шаардаж байгаа нь ажиглагдсан учраас энэ сэдвийг сонгох үндэслэл болсон. Хүн байгаль хичээлийг ажиглалт туршилтын аргаар явуулснаар нэг талаас сурагчдынхаа суралцах арга барилд, нөгөө талаас багшлах арга зүйд өөрчлөлт хийж чадсан. Өөрөөр хэлбэл амьдрах чадвартай бие даасан хувь хүнийг төлөвшүүлэхэд тус дөхөм болсон.

Судалгааны ажлын зорилго:

Хүн байгаль хичээлийг хичээлийн судалгааны арга зүйд тулгуурлан зохион байгуулснаар багш ажлын байрандаа хөгжих, сурагчид ажиглалт туршилтыг өөрийн биеэр хийх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх чадвар нь сайжран, бие биедээ туслах хамтран ажиллах хүмүүжил төлөвшинө.

Ямар судлагдахууныг сонгосон болох:

“Хүн байгаль”

Хамрах хүрээ:

Дорнод аймгийн Хэрлэн сумын Хан-Уул цогцолбор ᠗᠘᠔᠑᠒ ᠗᠐᠑᠗ сургуулийн 2-5-р ангийн сурагчид

Хичээлийн нэр	Ээлжит хичээлийн сэдэв	Сурагчийн тоо	Багшийн тоо
Хүн орчин	Бидний эрүүл мэнд	110	5
Эрүүл мэнд	Зөв хооллолт	114	5
Монгол хэл	Нар нахиа хоёрын яриа	99	4
Хүн байгаль	Дэлхий тэнхлэгээ тойрон эргэх нь	114	6
Хүн байгаль	Энерги	101	5
		538	25

Бага ангийн багш нараас гадна Хүн байгаль хичээлийн судалгаат хичээлд БГ-ын байгалийн ухааны гадаад мэргэжилтэн Тэрүми, Шимизү, сургагч багш Даваахүү болон сургалтад оролцсон Хэнтий Сүхбаатар, сумдын сургуулийн багш нар нэмж хамрагдсан.

Хугацаа:

Анх төсөлд хамрагдаж эхэлснээс хойш хичээлийн судалгааг өөрийн сургууль дээрээ нэвтрүүлэн ажиллахыг хичээж байна. Өөрөөр хэлбэл 5 жилийн ажил байна гэсэн үг.

Гол үйл ажиллагаа:

Монгол Улсын БШУЯ болон Японы Олон Улсын Хамтын ажиллагааны Байгууллага /ЖАЙКА/ хамтран хэрэгжүүлж буй “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн хүрээнд ХИЧЭЭЛИЙН СУДАЛГААГ хийснээр багшийн заах арга зүй, ур чадвар дээшилж, сургалтын хөтөлбөр сайжирч, САЙН ХИЧЭЭЛ-ийн санг бүрдүүлэхийн зэрэгцээ ажлын байрандаа хөгжих боломжийг бүрдүүлэх зорилгоор төлөвлөгөөтэй ажиллалаа. /ажлын төлөвлөгөөг хавсаргав./ Нэгдсэн төлөвлөгөөнөөс гадна секц бүрт хичээлийн судалгааг явуулах хууварийг гарган ажилладаг. Үүний нэг жишээ нь

Ч.Цогзолмаа

4-р ангийн Хүн байгаль хичээлийн “Энерги” сэдвээр хичээлийн судалгаа хийсэн тухай:

Хичээлийн судалгаагаар багш нар өөрийн арга зүйгээ бусад багш нартаа үлгэрлэн үзүүлж, тэднээс зөвлөгөө авах замаар арга зүйгээ улам сайжруулан түүнийгээ бусад багш нарт түгээн дэлгэрүүлэх учиртай. Сургалтын хөтөлбөрөө хамтран боловсруулж, хичээл заах, ажиглалт хийх, хичээлийн дараах хэлэлцүүлэг хийж арга зүйгээ улам сайжруулах, шинэ санаа оноог хэлэлцэх, хэрэгжүүлэх замаар хичээлийн судалгааг хийдэг.

Анги бүлэг бүрт хичээлийн судалгааг хийхдээ тусгайхуваарьгарганхэнхээээл бүлэгт,хэнхэнюугажиглах, хичээлийнхэлэлцүүлгийгхэзээнхийждахинсайжруулсанхөтөлбөрөөрөөхэрхэнзаахталаардэлгэрэнгү йхуваарьгарганажилласан. Тухайлбал: Хүн байгаль хичээлийн “Энерги” сэдвийг4-р ангийн бүх бүлэгт зааж хичээлийн судалгаа хийсэн хуваарийг танилцуулъя.

Анги	Сурагч ийн тоо	огноо	Хичээл заасан багшийн нэр	Хичээлд ажиглалт хийх хуваарь					
				Агуулга	Багшийн арга зүй	Сурагчийн үйл ажиллагаа	Хэрэглэг дэхүүн	Хичээлийн тэмдэглэл хөтлөх	Хичээлийн хэлэлцүүлэг хугацаа
4а	23	X/26	П.Жавзмаа	с/м	Жаргалмаа	Шинээ	Тэрүми	Гэрэлтуяа	X/26
4б	25	XI/16	П.Жавзмаа						XI/16
4в	28	X/31	Ч.Цогзолмаа	Сувд	Жаргалмаа	П.Жавзмаа	Тэрүми	Гэрэлтуяа	X/31
4г	25	XI/9	А.Жаргалмаа	с/м	Т.Сувд	П.Жавзмаа	Тэрүми	Гэрэлтуяа	XI/9

БГ-ын Байгалийн ухааны гадаад мэргэжилтэн Тэрүми багштай байнга хамтран бэлтгэл судалгааг хийж, ямар хэрэглэгдэхүүн ашиглан сурагчдаар туршилт хийлгэж мэдлэг бүтээлгэх вэ гэдгийг гол зорилгоо болгон ажилгласан. Бидний сонгосон туршилтаар багш, сурагч хоёр хамтран хэрхэн мэдлэг бүтээж буйд ажиглалт хийн дүгнэлт гарган дараагийн хичээлээ сайжруулан зааж байлаа.

Ажиглалт хийж буй багш нар дараах зүйлийг анхааран ажилласан. Үүнд:

- Багшийн асуулт тайлбар оновчтой эсэх
- Хичээлийн агуулгыг зөв сонгосон эсэх



- Сурагчдаар хийлгэсэн үйлдэл, туршилт бүр нь тодорхой зорилготой байсан эсэх
- Сурагч бүрт хүрч ажилласан эсэх
- Сурагчдад бодох хугацаа хангалттай олгож буй эсэх
- Сурагчдаас гарах бодит санааг төлөвлөсөн эсэх

Хичээлээс хичээлд сурагч болон багшид гарч буй өөрчлөлтийг ололтой тал, сул тал, түүнийг хэрхэн сайжруулах арга замыг тодорхойлох зорилгоор хэлэлцүүлгийг хийснээ харьцуулан харуулбал:

Хичээл	Хичээлд хэрэглэсэн туршилт	Ололттой тал	Сул талаа хэрхэн сайжруулах
I	Сэдэлүүлэлт Байцаа хуулах тоглоомоор - Бидний эргэн тойронд энерги байдаг гэдгийг биеэр нь мэдрүүлэхийг оролдсон. Туршилт 1 Ширээний чийдэн ашиглан гэрлийн болон дулааны энергийг мэдрүүлэх туршилт БИЧЛЭГТЭЙ	✓ Байцаа хуулах тоглоом нь сурагчдын сонирхолд нийцсэн. ✓ Самбар төлөвлөлт сайн.	➤ Багш асуултаа төлөвлөх ➤ Хариулт ирэх хугацааг тооцох ➤ Нарны энергийг мэдрүүлэхийн тулд эхлээд таамаглуулах дараа нь туршиж үзүүлэх хэрэгтэй байна. ➤ Энерги нь нэгээс нөгөөд шилждэг гэдгийг сурагчдын үгээр нь яриулах/Агуулга ихэдсэн/ ➤ Ширээний чийдэнг ашиглан гэрлийн энергийг мэдрүүлбэл ямар байна вэ? ➤ Ямар алхамд сурагчид таамаглал дэвшүүлэх, дүгнэлтийг бичих, ярих вэ

			гэдгийг төлөвлөх Чухам сурагчдыг ямар чадварыг үнэлэх вэ гэдгийг тооцох
II	Сэдэлжүүлэлт Байцаа хуулах тоглоом Туршилт 1 Цаасаар сэнс хийгээд яаж ажиллуулах вэ? Туршилт 2 Гэрлийн лампыг асаахын тулд цахилгаан хэлхээг үүсгэж үзэх БИЧЛЭГТЭЙ	✓ Багш дөхүүлэх асуулт тавьж буй байдал нь сайжирсан. ✓ Хичээлийн сэдэлжүүлэх үе шат оновчтой байсан. ✓ Самбар төлөвлөлт сайн байсан. Сэнсэнд дээрх туршилт нь хүүхдийн сонирхолд нийцсэн байв.	➤ Хичээлийн агуулга ихдэж цаг хэтэрсэн тул агуулгыг хасах ➤ Нарнаас энергийн төрлүүд ихэнх нь гарсан тул цахилгаан хэлхээ үүсгэх туршилтыг хасах саналтай байна. ➤ Сурагчдын дэвтэр хөтлөлтийг ажиглахын тулд ажиглалтын хуудас гарган хэрэглэсэн нь тохиромжгүй байсан тул дараагийн хичээлд дэвтэрт тэмдэглүүлэх ➤ Энерги нэгээс нөгөөд шилждэг гэдгийг багш заавал цахилгааны энерги гэрлийн энерги болон хувирч байна гэдгийг хэлүүлэх шаардлагагүй. Хэрэглээг бичих даалгаврыг өөрчлөх
III	Сэдэлжүүлэлт Бүгд дороо гүйсэн. Эндээс эрч хүчийг гаргах Туршилт 1 Нар болон сүүдэртэй газар – аягатай усыг тавьж харьцуулан ажиглах Туршилт 2 Цаасан сэнс хийж ажиллуулах 	✓ Самбар төлөвлөлт сайн. ✓ Сурагчдын дэвтэрт тэмдэглэл хөтлөлт боломжийн байсан. ✓ Цаасан сэнс	➤ Нарнаас дулаан ялгардаг гэдгийг шилтэй усаар туршилт хийсэн тул гарын алчуур байх хэрэгтэй. ➤ Цонх болон тавиур дээр тавьсан шилтэй усанд ялгаатай тэмдэглэл бичиж наах хэрэгтэй. ➤ Багшийн асуултыг сурагчдын хариулт ирэх боломжтой давхар төлөвлөх. ➤ Сурагчид дэвтэрт тэмдэглэл хөтлөхдөө зургаар илэрхийлэх сонирхолтой байгаа тул дараагийн хичээлд туршилтын үр дүнг зургаар илэрхийлүүлэх Хөдөөний айлууд салхин ба нарны энергийг юунд ашигладаг вэ гэдэг асуулт даалгаврыг сайжруулах

Ийнхүү 3 цагийн хичээлийг заасны дараа Энерги сэдвийг 1 цагт багтаан бидний эргэн тойронд төрөл бүрийн энерги байдаг. Энэ нь нэгээс нөгөөд шилждэг гэдгийг ойлгуулах боломжгүй гэдгийг мэдэрсэн. Ингээд Хүн байгаль судлагдахууны сургагч багш Даваахүү болон мэргэжилтэн Шимизү багш,зүүн бүсийн багш нарын сургалтан дээр оролцсон багш нартай хамтран хичээлийн бэлтгэл судалгааг хийснээр дулааны энерги, цахилгааны энерги ... тус бүрийг 1,1 цагаар заахаар

төлөвлөн дулааны энерги сэдвийг бэлтгэн заасан нь илүү үр дүнтэй хичээл болж, Дулааны энерги сэдвийн сайжруулсан хөтөлбөр гарсан.

Үйл ажиллагаа:

Хичээлийн судалгааг зохион байгуулснаар багш, сурагчид гарсан өөрчлөлт, хичээлийн судалгааны сайн болон сул тал, түүнийг хэрхэн сайжруулах талаар тоочин бичвэл:

Сурагчдыг хэрхэн хөгжүүлсэн болох

- ✓ Сурагчид хичээлд идэвхтэй оролцдог болсон
- ✓ Багаар хамтран ажиллах чадвар нь сайжирсан.
- ✓ Бусдыг сонсож, харилцан бие биедээ тусалж дэмждэг болсон.
- ✓ Сурагчид багштай харилцахдаа энгийн чөлөөтэй харьцдаг болсон
- ✓ Туршилтыг бие даан хийж, өөрийн санал дүгнэлтээ чөлөөтэй илэрхийлж сурсан.
- ✓

Багшийн арга зүй хэрхэн сайжирсан болох

- ✓ Байгалийн ухааны хичээлийг аль болох ажиглалт туршилтаар заахыг хичээдэг болсон.
- ✓ Багш нь ажиглалт туршилт судалгааны арга зүйд суралцсан.
- ✓ Гарын дор материалаар туршилтын хэрэглэгдэхүүнийг хийж сурсан.
- ✓ Хамтын ажиллагааны үр дүнд арга зүйгээ сайжруулж, өөрийн сайн тал, сул талыг мэдэрч засах шаардлагатай байгаа мэдрэн хичээлийн судалгааг санаачлан хийдэг болсон.
- ✓

Бие биенээсээ хэрхэн суралцсан болох

- ✓ Багш нар хичээлийн судалгааны бүхий л үе шатуудад /бэлтгэл судалгаа, хичээл заалт, хичээл ажиглалт, хичээлийн хэлэлцүүлэг/ харилцан суралцаж байдаг. Тухайлбал: Хичээлийн хэлэлцүүлгийн үед багшийн заасан арга зүй, төлөвлөлтийн талаар:
 - Давуу талыг тодруулан ярилцах
 - Сул талыг тодруулан хэлэлцэх
 - Сул талыг сайжруулах арга замаа хэлэлцэхэд хүртэл харицан суралцдаг байна.

Сайн тал

- ✓ Хамтран ажиллах, харилцан суралцах боломж бүрддэг.
- ✓ Багшийн мэдлэг, заах арга, ур чадвар хөгжих боломжтой.
- ✓ Сургалтын хөтөлбөр сайжирдаг.
- ✓ Сургалтын хэрэглэгдэхүүн сайжрахын зэрэгцээ багш гарын дор материалаа хэрэглэгдэхүүнийг хийх боломжоо хайн хэрэгжүүлдэг.
- ✓ Самбар төлөвлөлтийг хийж сурч байна.
- ✓ Ө°°°ēā°ð°° áíēíāñðóóēāðāāāíēíí°ðēēéíìàððēēāēāøēāēāāā.
- ✓ °ā°ðóòìûíàìüāðāēðāēðíēāíí°ē°āē°ēððēēāyā.
- ✓ Ò°ē°āē°ēðēēíāāðóððē÷ýýýýçāāāā.
- ✓ САЙН ХИЧЭЭЛ-ийн сандаа 5 ээлжит хичээлийн хөтөлбөртэй болсон.
- ✓ Ээлжит хичээлийн бэлтгэл сайжирснаар хичээлийн чанарт үр өгөөжөө өгөхийн зэрэгцээ сурагчид хөгжих, бие даан суралцах чадвар нь нэмэгддэг.

Сул тал

- Хичээлийн судалгаа хийхэд их хугацаа шаардлагатай байдаг учраас 1 ангид жилд 1 удаа л хийх боломж олддог.
- Ñóðāā÷āûí òàíēí ìýäýðçéí ð°āæēē ð°ē°āøēēēā ñóāēāð өөрөөр хэлбэл багш судлаач байна гэдгийг сайтар ойлгох энэ талаар мэдлэг чадвараа хөгжүүлэх шаардлагатай.
- Байгалийн ухааны хичээлийг зохион байгуулахад кабинетийн орчин, тоног төхөөрөмжөөр дутмаг байдаг.

Сул талыг засах арга зам

- Бага ангийн сургалтын хөтөлбөрийн агуулгад нийцүүлсэн мини лабораторитой байх хэрэгтэй байна.
- Багш бидний заадаг хичээлийн аль нь заахад бэрхшээлтэй байгаа вэ гэдгийг хэлэлцэн зөв сонголт хийж тухайн хичээлийн хүндэвтэр сэдвүүдийг хичээлийн судалгааны аргаар САЙН ХИЧЭЭЛ-ийг буй болгох энэ сэдвээ энэ жил заасан бол дараа жил дараагийн ангид дахин зааж турших ажлуудыг сургууль дээрээ зохион байгуулах шаардлагатай.

Ч.Цогзолмаа

- Байгалийн ухааны хичээлийн заахад онолын мэдлэг дутмаг байдаг тул энэ чиглэлээр мэргэжилтэн ажиллуулах саналтай байна.

Үнэлгээ:

Тус бага сургууль нь өөрийн төлөвлөсөн төлөвлөлтийн дагуу 5 судалгаат хичээлийг зохион байгуулан тайланг хэлэлцүүлэн ажилладаг. Хүн байгаль хичээлийн “Энерги сэдвийг” өөрийн сургууль дээр засан сайжруулан 3 удаа заасан хэдий ч хүүхдүүд энерги гэдгийг төдийлөн сайн ойлгож чадаагүй. Мөн энэ нэр томьёо нь хүртэл хүүхдэд ойлгоход хүндрэлтэй байсан. Бас энэ сэдвийг 3 цагт багтаах цагийн төлөвлөлттэй учир цагтаа баригдан төлөвлөлтийг өөрчилж чадахгүй байлаа. Ингээд бид гадаад мэргэжилтэн багш нартай хамтран хэлэлцээд энергийн төрлүүдийг нэг бүрчлэн 1,1 цагаар заахаар төлөвлөн Дулааны энерги ээлжит хичээлийг боловсруулан заасан нь үр дүнтэй байлаа. Энэ мэтээр хичээлийн судалгааны үр дүнг сайтар тооцож байх шаардлагатайг цаашид анхааран ажиллах болно.

Үр дүн:

Сургуульд суурилсан хичээлийг судалгааг зохион байгуулснаар багш ажлын байрандаа мэргэжил, заах арга ур чадвараа хөгжүүлж байна. Үүнд:

- Байгалийн ухааны хичээлийг туршилт ажиглалтын аргаар зохион явуулах арга хэлбэр нь нэмэгдсэн.
- Хичээл заах багшийг сонгохдоо залуу багшийн арга зүйг сайжруулах зорилготой байгаа бол бүх бүлэгт дахин дахин заалгах, ахмад багшаас бусад багш нар суралцах гэсэн зорилготой бол нэг бүлэгт 1 удаа л заалгахад боломжийн байсан.
- Хичээлд судалгаа хийн ажилласнаар багш хөгжөөд зогсохгүй сурагчдын сурах үйл ажиллагаанд ахиц гарч байгаа нь сургалтын үйл ажиллагаанаас ажиглагдсан. Иймээс энэхүү ажлыг тогтмол хийн хэвшж, зүйл нь зүйтэй, гэхдээ заахад хүндэвтэр сэдвийг сонгон заах нь илүү үр дүнтэй байна гэсэн дүгнэлтэд хүрлээ.

ХАМГИЙН ТОМ амжилт нь бага ангийн математик хичээлийн судлагдахууны багш С.Оюунтуяа нь амйгийн ур чадварын уралдаан амжилттай оролцон ДЭД байр эзэлсэн нь сургуульд суурилсан хичээлийн судалгааны хэрэгжилтийн үр дүн юм.

Сургуульд суурилсан хичээлийн судалгааг хэрэгжүүлэх талаар өөрийн хийсэн туршлагадаа тулгуурлан дараах санааг дэвшүүлж байна.

Бага ангийн багш нарын заах арга зүйг сайжруулах, багшлах ур чадварыг хөгжүүлэх, хичээлийн хөтөлбөрийг боловсронгуй болгох зорилгоор хичээлд анализ хийх багийг секц бүрээр зохион байгуулна.

Үйл ажиллагааны онцлог

- ✚ Бүлгийн багш нар заахад бэрхшээлтэй сэдвээ сонгон хамтран сургалтын хөтөлбөрө боловсруулна.
- ✚ Хичээлийн судалгаа бүрт зарцуулах хугацаа харилцан адилгүй. Хичээл тус бүр нь 1-2 удаа туршигдаж хэлэлцүүлэгт орсон байвал зүгээр байх

Ажиллах хэлбэр

- ✚ Судалгааны явцад бүлгийн багш нар нэгж хичээлийн төлөвлөгөөгөө хамтран боловсруулна.
- ✚ Тухайн бүлгийн нэг багш нь уг хөтөлбөрөөр хичээл зааж, бусад нь ажиглалт судалгаа хийж, хамтдаа хэлэлцүүлэг зохион байгуулна. Хичээлийг заах арга зүй ба хөтөлбөрийг сайжруулах үйл ажиллагааг хамтран явуулна.
- ✚ Судалгааны дараа бүлгээрээ тайлан бичнэ. Судалгааны үед юу сурсан, мэдсэн, харсан, дараа нь ямар шинэ зорилт тавих ... гэх мэт
- ✚ Сургуулийн захирал, сургалтын менежер, мэргэжлийн багш нарыг зөвлөх багшаар ажиллуулахад тохиромжтой.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Аливаа үйл ажиллагааны үр дүн хүний нөөцийн хүчин зүйлээр тодорхойлогддог учраас сургуулийг хөгжүүлэх, үйл ажиллагааных нь үр дүнг дээшлүүлэх, чанартай сургалт явуулах зорилгыг хэрэгжүүлэхийн тулд нэн түрүүн багшийг хөгжүүлэх зорилго дэвшигдэнэ. Багшийг хөгжүүлэхийн тулд мэргэжил дээшлүүлэлтийг тасралтгүй явуулах шаардлага гарч байна. Багш нарын мэргэжил дээшлүүлэх хэлбэрүүдийн дотор багшийн мэргэжил, сэдвэд дээр дээшлүүлэх сургалтыг сургууль дээр нь тухайн сургуулийн хичээл сургалтын бодит амьдралтай холбон зохион байгуулах хэлбэрийг дэлхийн нийтийн түвшинд маш чухалчлан үзэх болсон.

Ч.Цогзолмаа

Сургуулийн удирдлага багш нартайгаа хамтран өөрсдийн нөхцөл боломжин дээрээ тулгуурлан багш нарынхаа цаашдын ажлын байран дээр нь дээшлүүлэх боломжөөгөө илэрхийлэв. Ийм учраас гагцхүү сургуулийн удирдлага болон тэнд ажиллаж буй багш нарын идэвх санаачлага л чухал юм.

Багшийн цаашдын ажлыг чанартай сургалт явуулах нөхцөл бүрдэнэ. Иймд чанартай сургалт явуулахын тулд багш хичээлээ төлөвлөхдөө судлаачийн байр сууринаас хандан сургалтын хөтөлбөрийг чанартай боловсруулан сургалтаа зохион байгуулж, тэрхүү сургалтандаа дүн шинжилгээ хийн ажиллах шаардлагатай байна. Ажлын дүнд бичээлийн судалгаа гэдэг нь багш нар арга зүйгээ сайжруулах, багшлах ур чадвараа хөгжүүлэх чиглэлээр явуулж буй үйл ажиллагаа юм.

Иймээс цаашид хичээлийн судалгааны багийг чанартай зохион байгуулж багш нарынхаа заах арга, ур чадварыг дээшлүүлэн сурагчдын суралцахуйг дэмжсэн сургалт зохион байгуулснаар нийгэмдээ бие даан амьдрах чадвартай иргэн төлөвшүүлнэ гэдэгт итгэл дүүрэн байна.

Цаашид хөгжүүлэх санал:

- Бусад аймгийн тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх

Хичээлийн судалгааны явцын фото агшин:



Нэг багш дагнан 3 бүлэгт нэг хичээлийн заасан нь багш өмнөх алдаагаа дахин давтахгүй сайжруулах боломжтой байгаа нь ажиглагдсан.



Самбар төлөвлөлтийг хичээл бүрийн хэлэлцүүлэгт засан сайжруулах чиглэлээр ярилцсаны үр дүнд төлөвлөлт сайжирч байгаа нь харагдсан.



Хичээл 1



Хичээл 2



Хичээл 3

Ном зүй

1. БСШУ-ны сайдын 2007 оны 354 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт “ЕБС-ийн багшийн ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолт “
2. Засгийн газрын 2008 оны 316 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”
3. БСШУЯ, ЖАЙКА-ийн хамтарсан төсөл “ Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил”, “ Хичээлд мониторинг хийх зөвлөмж”, УБ, 2009
4. БСШУЯ, ЖАЙКА-ийн хамтарсан төсөл “ Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх нь” зөвлөмж
5. БСШУЯ, ЖАЙКА-ийн хамтарсан төсөл “ Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил” зөвлөмжүүд
6. БСШУЯ, ЖАЙКА-ийн хамтарсан төсөл “ Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил”, “ Амьд биеийн хөгжлийг таниулах арга зүй”, Зөвлөмж – I, УБ, 2007